



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.04.08 № А-1/1504  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД**

**Тодруулгын хариу  
хүргүүлэх тухай**

Тус газраас зарласан ЗТХЯ/202412009 дугаартай XV.1.1.53 Жаргалтхаан-Дэлгэрхаан чиглэлийн хатуу хучилттай авто зам, 59.2 км Хэнтий, Жаргалтхаан, Дэлгэрхаан сум” УТ2402804409 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

Тодруулга	Хариулт
<p>Тус тендерийн баримт бичгээс: 1.ТШЗ 19.3-ын шаардлага: 2.8.1.7 Гүүрийн туннелийн зураг төсөл боловсруулах эсхүл 5.2.3.2 Замын байгууламж барих /”Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага батлах тухай” Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал/ гэсэн шаардлагыг “Зам, тээврийн хөгжлийн яам”-ны 2.8.2.3 Бүх төрлийн гүүр, туннель, үерийн хамгаалалтын далан барих, 2.8.5.2 Бүх төрлийн гүүр, туннель, газар доогуур нүхэн гармын арчлалт, урсгал засвар, ээлжит засварын ажил гэсэн тусгай зөвшөөрлөөр хангаж болох эсэх, 2. ТШЗ 19.1 Ажил гүйцэтгэх хүний нөөцөд санал болгох инженер техникийн ажилчдаас ямар албан тушаалтай ажилчдыг гэрээт ажилтнаар тооцож болох талаар дээрх шаардлагуудад тодруулга гаргаж өгнө үү.</p>	<p>1.Зам тээврийн хөгжлийн яамнаас олгодог Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/177 дугаар “Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага батлах тухай” тушаалаар батлагдсан 5.2.3.2 Замын байгууламж барих /Бүх төрлийн замын байгууламжийг барих-бүх төрлийн гүүр, туннель, газар доогуур нүхэн гарам барих/ тусгай зөвшөөрөл нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/101 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан 2.8.2.3 Бүх төрлийн гүүр, туннель, үерийн хамгаалалтын далан барих тусгай зөвшөөрөлтэй дүйцнэ. 2.Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.2 Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд: в)Тендерт оролцогчийн үндсэн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана. Бусад ажилтны хөлсөөр ажиллах гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай. -Тендерийн баримт бичигт санал болгож буй инженер, техникийн ажилтныг үндсэн эсхүл хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр гэж тухайлан заагаагүй болно. -Тусгай зөвшөөрлийн хүрээнд инженер, техникийн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг шалгана.</p>

1324024038

Тодруулгатай холбоотойгоор тендерийн баримт бичгийн ТШЗ19.3:

Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: Шаардана.

Зам, тээврийн хөгжлийн яамны:

2.8.2.1.3 15 км болон түүнээс дээш хатуу хучилттай авто зам барих эсхүл 5.2.3.1 авто зам барих /"Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага батлах тухай" Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал/,

2.8.1.7 Гүүр туннелийн зураг төсөл боловсруулах эсхүл 5.2.3.2 Замын байгууламж барих /"Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага батлах тухай" Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал/.

Эрчим хүчний яамны:

ТЗ-2.1. 0.4-15кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ;

Уг ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим системээс шалгана. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй өөрийн зөвшөөрлийн талаар мэдээллийг бүрэн, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг шалгах үүрэгтэй." гэснийг

Зам, тээврийн хөгжлийн яамны:

5.2.3.1 Авто зам барих /"Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага батлах тухай" Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал/,

5.2.3.2 Замын байгууламж барих /"Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага батлах тухай" Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал/.

/Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс өмнө олгогдсон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийг төрөл ангилалын хувьд дүйцүүлэн ашиглана./

Эрчим хүчний яамны:

ТЗ-2.1. 0.4-15кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ;

Уг ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим системээс шалгана. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй өөрийн зөвшөөрлийн талаар мэдээллийг бүрэн, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг шалгах үүрэгтэй." гэж өөрчилсөн болно.

ДАРГА



Ц.БАТЗУЛ